

МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 9/352

Мандалговь

Г Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд гамшигаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгээс өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хугацааг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл тогтоосугай.

Хоёр. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журмыг мөрдөж, онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэн амны хаалт хэрэглэн, хоорондын зайд барьж, гараа тогтмол угааж, ариутгаж байхыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

Гурав. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх ресторан, баар, караоке, нийтийн хоолны үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

Дөрөв. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа хичээл сургалт, семинар, цугларалт, хэлэлцүүлэг, дамжаа, курс, секц, дугуйлан, сүм хийдийн хурал, үзвэр, РС тоглоом, спорт заал, уралдаан тэмцээн, фитнесийн үйл ажиллагааг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

Тав. Хот, аймаг, сумд хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүйгээр өнгөрүүлсүгэй.

Зургаа. Төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимд шилжүүлсэн цагийн хуваарийг баталж мөрдүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

Долоо. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, авч хэрэгжүүлж буй ажлын явц, үр дүнг тухай бүр нь танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

482011018